

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ,
ӨГӨГДӨЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН МӨНХЖАРГАЛЫН НОМИНГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/ д | Зорилтыг хэрэгжүүлэх хэмжээ | арга | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
|--|--|-------------------------------------|---------------------|---------------------|--|-------------------------------|------|--|--------------------------------|------------------------|
| | | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | | | | |
| Зорилт 1. Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах зорилтын хүрээнд | | | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдөл нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, тайлагнах | Tайлангийн тоо | - | 2 | "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"- ын 5.1 дэх хэсэгт "Мэдээлэл хариуцагч нь нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх, шинэчлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж, хариуцсан албан хаагчийг томилж, ажиллуулна." гэж заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/99 тоот албан бичгийг "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"- аар батлагдсан 57 байгууллага руу хүргүүлснээс 35 байгууллага нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны албан хаагчийг томилон ирүүлсэн. Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн хэрэгжилт хэлэлцэх танилцуулгад мэдээлэл бэлтгэсэн. | 2025.01.02 - 2025.06.15 | 100% | | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулахаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/82 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 1 | 1 | 2025.01.15 - 2025.06.15 | 30% | | | | |

| | | | | | | | |
|----|---|---|---|---|---|-------------------------------|-----|
| | байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | | | | хүрээнд тогтоолын төслийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг судалж байна. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрт шилжүүлж, ил тод, нээлттэй болгоно. | Нэвтрүүлсэн системийн тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 2025.06.15 - 2025.06.15 | - |
| 4. | Арга хэмжээ 1.4. Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгоход иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлнэ. | Шалгах талбар нэмэх чиглэлээр бүртгэлийн журамд оруулсан нэмэлт, өөрчлөлт | - | - | "Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх" ажлын хүрээнд Нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил болгоход иргэн шууд хяналт тавих боломжийг бүрдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 2025.03.15 - 2025.06.15 | 30% |

| | | | | | | | |
|----|---|--|------|-----|---|-------------------------------|------|
| 5. | Арга хэмжээ 1.5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагуудыг "shilen.gov.mn" системд хамруулах | Системд бүртгэл үсгэсэн байгууллагын тоо | 1571 | 500 | <p>"Нээлттэй мэдээллийн систем (www.shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг ашиглалтад нэвтрүүлсэн. Тус системд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 4039 байгууллагыг бүртгэн, 4095 албан хаагчид системд хандах эрх олгоод байна.</p> <p>Тус системд иргэний хяналт тавих боломжийг бүрдүүлж, нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг 2025 онд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. shilen.gov.mn</p> | 2025.01.15 - 2025.06.15 | 100% |
|----|---|--|------|-----|---|-------------------------------|------|

Зорилт 2. Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах зорилтын хүрээнд

| | | | | | | | |
|----|---|----------------------|-----|---|---|-------------------------------|-----|
| 1. | Арга хэмжээ 2.1. Яамны төлөвлөгөөний 63. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-ийн 3.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | Нэвтрүүлсэн хувилбар | 2.0 | - | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/88 дугаар тушаалаар "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-ийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх" ЦХИХХЯ/20250103045 дугаар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Тайлант хугацаа болоогүй. | 2025.04.15 - 2025.06.15 | 70% |
| 2. | Арга хэмжээ 2.2. Яамны төлөвлөгөөний 65. Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | Нэвтрүүлсэн хувилбар | 2.0 | - | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/88 дугаар тушаалаар "Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх" ЦХИХХЯ/20250103046 дугаар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулагдсан. Тайлант хугацаа болоогүй. | 2025.04.15 - 2025.06.15 | 70% |

| | | | | | | | |
|----|--|--------------------|-----|----|--|-------------------------------|------|
| 3. | Арга хэмжээ 2.3. Яамны төлөвлөгөөний 43. Шил ажиллагааны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчилна. | Арга хэмжээний тоо | - | 0 | <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn) 2.0 хувилбарт шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, баталгаажуулах, хэвлэн нийтлэх, мэдээлэл шинэчлэх талаар цуврал сургалтыг бэлтгэн хүн, хуулийн этгээдэд хүргэх ажлыг зохион байгуулж, мөн ТЦҮЗГ-аас нээлттэй мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор Монголын Үндэсний Олон нийтийн телевиз, Ийгл телевизүүдээр мэдээллийг хүргэсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны "Штаб шинэчлэн байгуулах тухай" А/46 дугаар тушаалын дагуу Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран мэдээлэл хариуцагч байгууллага хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг ил тод байршуулсан эсэхэд Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-ээр дамжуулан үнэлгээ өгэн, холбогдох заавар, мэдээллээр ханган ажилаж, 2,794 албан хаагчдыг сургалтад хамруулаад байна.</p> | 2025.06.15 - 2025.06.15 | 100% |
| 4. | Арга хэмжээ 2.4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг албан ёсны цахим хуудаст байршуулсан эсэхэд үнэлгээ хийх | Үнэлгээний тоо | 571 | 16 | <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу цахим хуудсандaa нээлттэй байршуулах 67 төрлийн мэдээлэлд үнэлгээ хийж "Шилэн Индекс"-ийг системд нийтэлсэн. 2025 оны I улирлын байдлаар нийт 1135 тайлан илгээж, 1126 байгууллага үнэлгэдээд байна. "Шилэн Индекс"-ийн тайлан ирүүлсэн байгууллагын үр дүн: Төрийн захиргааны төв байгууллага 92.61% (Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газар болон 11 яам), Төрийн захиргааны байгууллага 79.61% (23 агентлаг), Нийслэлийн Засаг Даргын тамгын газар 55.59% (6 ЗДТГ), Нутгийн захиргааны байгууллага 75.84% (14 аймаг) гэсэн тус тус үзүүлэлттэй байна. Тус яам 2025 оны 1 дүгээр улирлын "Шилэн Индекс"-ийн тайланг илгээж 97,96% үнэлгэдсэн байна. Мөн салбар байгууллагуудын ирүүлсэн тайлангийн үнэлгэдсэн хувь: Харилцаа холбооны зохицуулах хороо 98%, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар 96%, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК 95%, Үндэсний дата төв 89% И-Монгол академи УТҮГ 89%-тай тус тус үнэлгэдсэн. Нээлттэй мэдээллийн нийт 45 төрлийн 970,355 мэдээллийг дор дурдсан чиглэлээр байршуулж, 15,784,843 удаагийн хандалтыг аваад байна. Shilen.gov.mn</p> | 2025.01.15 - 2025.06.15 | 100% |

Зорилт 3. Цахим орчинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөв зохистой хэрэглээний соёлыг нэвтрүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулах, иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд

| | | | | | | | |
|----|---|---|---|---|---|-------------------------------|-----|
| 5. | Арга хэмжээ 3.1. Нээлттэй өгөгдэл, их өгөгдлийн чиглэлээр төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулна. | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | - | "Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх" ажлын хурээнд мэдээлэл хариуцагч байгууллагын өгөгдэл хариуцсан албан хаагч нарт 2025 оны 09 дугаар сард нээлттэй өгөгдэл, их өгөгдлийн чиглэлээр сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Тайлант хугацаа болоогүй. | 2025.06.15 - 2025.06.15 | 30% |
|----|---|---|---|---|---|-------------------------------|-----|

Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд

| | | | | | | | |
|----|--|--|---|---|---|-------------------------------|------|
| 1. | Арга хэмжээ 3.1. Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж батлуулах, тайлагнах | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо, ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо, | - | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо - 1 ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо - 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, нэгжийн удирдлагаар батлуулж, батлагдсан загварын дагуу биелэлтийг гаргасан. | 2025.01.05 - 2025.06.15 | 100% |
| 2. | Арга хэмжээ 3.2. Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх | - | Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна. | -Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй 67 төрлийн мэдээллийн "Шилэн Индекс"-ийг 2024 оны IV улирлын байдлаар Авлигатай тэмцэх газрын комиссар (Б.Бямбадорж)-д хүргүүлсэн. - Шил индекс 2024 оны эрчим хүчний салбарын үнэлгээг 98 үзүүлэлтийн задаргаагаар Нийцлийн аудитын газрын ахлах аудитор (С.Дарьмаа)-д хүргүүлсэн. -Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх, нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулга хийж, мэдээлэл өгсөн. | 2025.01.15 - 2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|----|--|--|---|---------------|---|-------------------------------|------|
| | Арга хэмжээ 3.3. Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн эсэх | - | Хэрэгжилт ээр | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/268, А/48 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн ажиллах журам"-ын 2.2-т заасны дагуу "Зөвлөлийн үйл ажиллагааны 2025 оны эхний хагас жилийн төлөвлөгөө", "Үнэлгээний хуваарь"-ийг батлуулсан. | 2025.01.15 - 2025.06.15 | 100% |
| 4. | Арга хэмжээ 3.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж Үүсгэсэн эсэх | Хууль болон холбогдох журамд нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөж, архивын нэгж Үүсгэсэн эсэх | - | Хэрэгжилт ээр | Тус яамны 2024 оны худалдан авах төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд зохион байгуулсан А/66, А/69 тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны худалдан авах үйл ажиллагааны 3 хавтас материалыг архивласан. | 2025.01.15 - 2025.06.15 | 100% |
| 5. | Арга хэмжээ 3.5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдолыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн тоо | Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн тоо | - | Хэрэгжилт ээр | 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар чиг үүргийн хүрээнд өргөдөл, гомдол хуваарилагдаагүй байна. | 2025.01.15 - 2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|----|---|---|---|--|---|-------------------------|------|
| 6. | Арга хэмжээ 3.6. Авлигын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг хангах | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо | - | ХАСХОМЭ дүүлэг - 1 Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо-хэрэгжилтээр | Тайлант хугацаанд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг тус тус хугацаанд нь мэдүүлж, баталгааны маягтыг баталгаажуулж Салбарын эрх зүйн асуудал хариуцсан шинжээч (Б.Солонго)-д хүргүүлсэн. | 2025.01.15 - 2025.06.15 | 100% |
|----|---|---|---|--|---|-------------------------|------|

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|-----|--|----------------------------|--------------|--|---|--------------------------|-----------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Судалгааны нэгдсэн системийн хөгжүүлэлт, түүний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд | Өгсөн үүрэг даалгаврын тоо | | Судалгааны нэгдсэн системийн хөгжүүлэлт, түүний хэвийн үйл ажиллагааг хангах | Үндэсний судалгааны нэгдсэн платформ (sudalgaagov.mn)-д 2025 оны 06 сарын 06-ны өдрийн байдааар 2114 судалгааг мэдээлэл хариуцагч байгууллагууд байршуулсан байна. Судалгааны нэгдсэн платформын хэрэглэгчийн гарын авлагыг шинэчлэн тус платформд байршуулсан sudalgaagov.mn . | 2025.01.15-2025.06.15 | 100% |
| 2. | Төрийн нарийн бичгийн даргын А/93, А/96 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах | Өгсөн үүрэг даалгаврын тоо | | 2 | Тус яамны 2025 оны худалдан авах төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд төрийн нарийн бичгийн даргын А/93, А/96 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. | 2025.01.15-2025.06.15 | 100% |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|-----|---|--|---------------------|--------------|---|--------------------------|-----------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | |
| 1. | Чиг үүргийн хүрээнд сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | - | 1 | 2025 оны 02 дугаар сарын 13 -ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн анхдугаар хэлэлцүүлэгт хамрагдсан. | 2025.01.15-2025.06.15 | 100% |
| 2. | Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцож | Сургалт, хурал, семинарт оролцсон байна. | - | 2 | -2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Кибер аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний тайлангийн хуралд хамрагдсан. -Дэлхийн банкны Ухаалаг засаг төслийн хүрээнд Тархмал цахим үнэмлэхийн хэлэлцүүлэгт хамрагдсан. | 2025.01.01-2025.12.15 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нээлттэй мэдээлэл, өгөгдөл хариуцсан
мэргэжилтэн
(Албан тушаал)


/М.Номин /
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)